



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/128


Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, 31.1.5 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь хэсэг, МУИС-ийн Ректорын зөвлөлийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын их сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. “Монгол Улсын их сургуульд гадаадын иргэн суралцуулах журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан МУИС-ийн Захирлын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/113 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар), бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, алба нэгжийн удирдлагад тус тус даалгасугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

Ректорын 2025 оны 05 дугаар сарын 19 -ны
өдрийн 1/128 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД
ГАДААДЫН ИРГЭНИЙГ СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ




Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны гэрээний дагуу болон хувийн төлбөрөөр суралцах гадаадын иргэнийг Монгол Улсын Их Сургууль (цаашид МУИС гэх)-д суралцуулах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон МУИС-ийн холбогдох журмыг үндэслэн МУИС-ийн боловсролын зэрэг олгох болон зэргийн бус сургалтад гадаадын иргэнийг суралцуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.3 Энэ журмаар зохицуулагдаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, МУИС-ийн дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.

Хоёр. Журмын нэр томьёо

- 2.1 *Гадаадын иргэн* гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг;
- 2.2 *Боловсролын зэрэг олгох сургалт* гэж МУИС-ийн бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтыг;
- 2.3 *Зэргийн бус сургалт* гэж монгол хэлний бэлтгэл, оюутан солилцоо, мэргэших дадлага (интерншип), зуны сургалтын хөтөлбөрүүдийг;
- 2.4 *Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр* гэж Монгол Улсын дээд боловсролын байгууллагад суралцах хүсэлтэй болон монгол хэл суралцах сонирхолтой, тус улсад оршин суугаа гадаадын иргэдэд зориулсан түр хугацааны зэргийн бус сургалтыг;
- 2.5 *Оюутан солилцооны хөтөлбөр* гэж МУИС, бүрэлдэхүүн/салбар сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их, дээд сургуулиас зэргийн болон зэргийн бус хөтөлбөрт ирж суралцах, нөгөө талаас МУИС-ийн суралцагч уг хамтын ажиллагаатай сургуулийн сургалтын хөтөлбөрт хамрагдахыг хэлнэ. Мөн МУИС, бүрэлдэхүүн/салбар сургуулийн хэрэгжүүлж буй олон улсын төсөл, хөтөлбөрөөр суралцах суралцагчийг;
- 2.6 *Зуны сургалтын хөтөлбөр* гэж монгол хэл, соёл, орчинтой танилцах, тодорхой чиглэлээр суралцах, судалгаа хийх хүсэлтэй гадаадын иргэдэд зориулсан богино хугацааны сургалтыг;
- 2.7 *Мэргэжих дадлага (интерншип)* гэж хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их, дээд сургуулиас болон профессор багшийн хамтарсан судалгааны хүрээнд суралцагч тодорхой мэргэжил, судалгааны чиглэлээр дадлагажих хөтөлбөрийг;

- 2.8 Цагаач гэж Монгол Улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;
- 2.9 Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж гэж тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч МУИС-ийн сургалт, судалгааны нэгжийг;
- 2.10 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж гэж Оюутны хөгжил, үйлчилгээний нэгжийн удирдлага, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнийг;
- 2.11 Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж гэж Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгжийн удирдлага, хариуцсан мэргэжилтнийг гэж тус тус ойлгоно.



Гурав. Гадаадын иргэнд тавих шаардлага

- 3.1 Монгол Улсын харьяат бус гадаадын иргэн оршин суугаа газраас үл хамааран энэ журмын хүрээнд МУИС-д суралцах хүсэлт гаргаж болно.
- 3.2 МУИС-ийн боловсролын зэрэг олгох сургалтад суралцах гадаадын иргэн нь Монгол Улсад мөрдөгдөж буй боловсролын агуулгын түвшин, стандарттай дүйцэхүйц өмнөх шатны боловсрол эзэмшсэн байна.
- 3.3 Гадаадын иргэн нь боловсролын зэрэг олгох хөтөлбөрт суралцах бол монгол хэлийг дунд болон дундаас дээш түвшинд эзэмшсэн гэдгийг нотлох диплом, гэрчилгээний (Олон улсын монгол хэлний шалгалт TOMFL эсвэл МУИС-ийн монгол хэлний бэлтгэл хөтөлбөрийг амжилттай төгссөн гэрчилгээ) баталгаажуулсан хуулбарыг элсэх хүсэлт гаргах үед ирүүлнэ. Монгол Улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн бол элсэлтийн шалгалт өгсөн байна (ЭШ нь зөвхөн бакалаврын хөтөлбөрт хамаарна).
- 3.4 Монгол хэлний зохих шаардлага хангаагүй гадаадын иргэн монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт хамрагдан, дунд болон ахисан түвшнийг амжилттай төгссөний дараа боловсролын зэрэг олгох сургалтад элсэн суралцаж болно.
- 3.5 Англи хэлээр боловсролын зэрэг олгох хөтөлбөрийн хувьд гадаадын иргэнээс монгол хэлний мэдлэг, чадвартай байхыг шаардахгүй боловч тухайн хөтөлбөрийн шаардлагад нийцсэн англи хэлний түвшинтэй байхыг шаардаж болно. Энэ тохиолдолд англи хэлний мэдлэг, чадварын түвшнийг нотлох бичиг баримтыг (TOEFL, IELTS зэрэг шалгалтын оноо нь хүчинтэй гэрчилгээ) элсэх хүсэлт гаргах үед хавсаргаж ирүүлнэ.

Дөрөв. Элсэн суралцах хүсэлт гаргах

- 4.1 Боловсролын зэрэг олгох сургалтад хамрагдан суралцах хүсэлтэй гадаадын иргэн нь заасан хугацаанд МУИС-ийн <http://registration.num.edu.mn> хаягаар цахим хэлбэрээр бүртгүүлнэ. Шаардлагатай тохиолдолд өргөдлийн маягыг бөглөн холбогдох бичиг баримтын хамт foreignadmission@num.edu.mn цахим шуудангаар илгээж болно.
- 4.2 Элсэлтийн үйл ажиллагааг түвшин харгалзахгүй хичээлийн жилд хоёр удаа зохион байгуулна.
- 4.3 Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн танилцуулга, элсэлтийн үйл ажиллагаанд холбогдох бусад мэдээллийг МУИС-ийн веб хуудсанд монгол, англи хэлээр тогтмол байршуулна.

- 4.4 Элсэн суралцах хүсэлтийг түвшин харгалзахгүй намрын улиралд 05 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 01-ний дотор, хаврын улиралд 10 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж бүртгүүлнэ.
- 4.5 Гадаадын иргэн адил түвшний хэдэн ч хөтөлбөрт хүсэлт гаргаж болох бөгөөд цахимаар болон бусад зөвшөөрөгдсөн хэлбэрээр бүртгүүлж, бүртгэлийн хураамж төлснөөр хүсэлт баталгаажна.
- 4.6 Элсэн суралцах хүсэлт гаргаж буй гадаадын иргэн заасан хугацаанд багтаан дараах бичиг баримтуудыг бүрдүүлэн цахимаар бүртгүүлнэ. Үүнд:
- 4.6.1 Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшнийг илтгэх диплом, дүнгийн хавсралтын хамт (МУИС-д биечлэн ирж бүртгүүлэхдээ эх хувийг нотариатаар баталгаажуулсан хуулбар болон албан ёсны тамгатай баталгаат орчуулгаар монгол хэлээр орчуулсан орчуулгын эх хувийг бүртгэлийн мэргэжилтэнд бүрдүүлж өгнө);
- 4.6.2 Гадаад паспорт (хүчинтэй хугацаа 6 сараас дээш байх);
- 4.6.3 Монгол Улсад суралцах хугацааны сургалтын төлбөр амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан 1 жилийн сургалтын төлбөр, дотуур байрны төлбөртэй тэнцэх хэмжээний санхүүгийн баталгаа (тэтгэлэг, банкны тодорхойлолт болон түүнтэй дүйцэх баталгаа);
- 4.6.4 Магистр, докторын хөтөлбөрт элсэх гадаадын иргэний мэдлэг боловсрол, ажлын туршлага, суралцах арга барилыг нь тодорхойлсон суралцах төлөвлөгөө болон профессор багшийн тодорхойлолт;
- 4.6.5 Монгол эсвэл англи хэлний мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох гэрчилгээ;
- 4.6.6 Дижитал цээж зураг (сүүлийн 6 сарын дотор авхуулсан, 3x4 хэмжээтэй байх).
- 4.7 Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцаж буй гадаадын иргэний хувьд элсэлтийн хугацаанд боловсролын зэргийн сургалтад элсэх хүсэлтийг системээр гаргаж бүртгүүлнэ.
- 4.8 Бүрдүүлэх материал дутуу, баримт бичгийн зөрчилтэй, холбоо барих хаяг тодорхойгүй бүртгүүлэгчийг элсэх бүртгэлээс хасна.
- 4.9 Дээр дурдсан хугацаанаас хоцорсон хүсэлтийг хүлээн авахгүй.

Тав. Элсэх хүсэлтийг шийдвэрлэх, мэдэгдэх

- 5.1 Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь суралцах хүсэлт гаргасан гадаадын иргэний бичиг баримтыг хүсэлт гаргах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор хянана.
- 5.2 Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь шаардлага хангасан бүртгүүлэгчийн мэдээллийг гадаад иргэний элсэлтийн комисст хүргүүлнэ. Элсэлтийн комисс жагсаалт ирүүлснээс хойш ажлын 5 хоногт багтаан шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, тэнцсэн элсэгчдийн нэрсийг Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 5.3 Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь суралцах эрхээ авсан элсэгчид суралцагчийн хувийн дугаар, мэдээллийн

удирдлагын системд нэвтрэх эрх, нууц үг олгож, бүртгүүлсэн мэйл хаягаар нь мэдэгдэнэ.

- 5.4 Монгол хэлний бэлтгэл ангид элсэгчийн монгол хэлний түвшнийг бүртгэлийн системд байршуулсан түвшин тогтоох жишиг сорилгоор тогтоорно.
- 5.5 Зэрэг олгох хөтөлбөрт элсэгч нь олон улсын монгол хэлний шалгалтын (ТОМFL) М3 ба түүнээс дээш оноотой эсвэл МУИС-ийн монгол хэлний бэлтгэл хөтөлбөрийн дундаас дээш түвшний 2,8 болон түүнээс дээш голч оноотой төгссөн гэрчилгээтэй байна.
- 5.6 Ахисан түвшинд хүсэлт гаргагч нь 5.5-д заасан шалгуур эсвэл англи хэлний TOEFL (iBT 60-аас доошгүй), IELTS (5.5-аас доошгүй) зэрэг шалгалтын хүчинтэй гэрчилгээтэй тохиолдолд мэргэжлийн шалгалтад орно.
- 5.7 Элсэлтийн шийдвэрийг үндэслэн Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь гадаадын иргэнд суралцах эрхийн бичгийг цахим шуудан эсвэл баталгаат шуудангаар илгээх ба холбогдох мэдээллийг өгсөн байна. Илгээх мэдээлэлд Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтуудыг багтаасан санамж бичиг, виз болон оршин суух зөвшөөрлийн хураамж, бүртгэлийн хураамж, сургалтын төлбөр, дотуур байр, амьдрах орчны талаарх мэдээлэл, сургуульд ирж бүртгэл баталгаажуулах хугацаа зэргийг заавал дурдана.
- 5.8 Суралцах эрх нь хичээлийн жилийн дараалсан хоёр улиралд хүчинтэй.
- 5.9 Суралцах эрх авсан гадаадын иргэн Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжээс Монгол Улсад суралцах виз, зөвшөөрлийн тухай мэдээлэл авч болно.
- 5.10 Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах гадаадын иргэдийг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн МУИС-ийн ректорын тушаалаар шууд элсүүлэн суралцуулна.
- 5.11 Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд МУИС-д элсүүлэхгүй бөгөөд элссэн тохиолдолд суралцах эрхийг цуцална.

Зургаа. Суралцагчийг хүлээн авах, бүртгэх, байрлуулах

- 6.1 Бүх түвшний суралцах эрх авсан элсэгч тухайн улирлын хичээл эхлэхээс 7-14 хоногийн өмнө Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгжид зохих баримт бичгүүдийг биечлэн өгч, бүртгэлээ баталгаажуулна.
- 6.2 Гэрээнд гадаадын иргэний суралцах хугацаа, тэтгэлэг, сургалтын болон бусад төлбөрийн дүн, амьдрах байр, суралцах орчин, нөхцөл, эрүүл мэнд, даатгал, хүлээх үүрэг, хариуцлага болон бусад асуудлыг тусгасан байна.
- 6.3 Гэрээ байгуулсан гадаадын иргэнийг МУИС-ийн ректорын тушаалаар элсүүлэн, Боловсролын асуудал хариуцсан төв байгууллагын системд бүртгэнэ.
- 6.4 Бүртгүүлсэн гадаадын иргэн тухайн улиралд суралцах багц цагийн төлбөрөө төлж, хичээл сонголт хийснээр сургалтын үйлчилгээг авах эрх нээгдэнэ.
- 6.5 Хичээлийн жил эхлэхээс өмнөх долоо хоногт багтаан гадаад иргэнийг чиглүүлэх, сургалттай холбоотой үйлчилгээ, хичээл сонголтын зөвлөгөө өгөх


- ажлыг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж, Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж хамтран зохион байгуулна.
- 6.6 Суралцах эрх авсан гадаадын иргэн нь оюутны дотуур байранд амьдрах болон угтах үйлчилгээ авах талаар Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид урьдчилан мэдэгдсэн байна.
- 6.7 Хүсэлтийн дагуу гадаад суралцагчийг угтах, тосох, оюутны дотуур байранд байрлуулах, гэрээ байгуулах асуудлыг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж зохион байгуулна.
- 6.8 Оюутны дотуур байранд хүсэлт гаргасан гадаад суралцагчийг байрлуулахад дараах эрэмбийг баримтална.
- 6.8.1 Засгийн газар хоорондын болон хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах;
- 6.8.2 Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт элсэн суралцах;
- 6.8.3 Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт элсэн суралцах;
- 6.8.4 Бусад.
- 6.9 Гадаадын иргэн нь Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид гаргана. Ингэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 6.9.1 Паспортын хуулбар;
- 6.9.2 Оршин суугаа газрын тодорхойлолт;
- 6.9.3 Сургалтын төлбөр төлсөн баримт;
- 6.9.4 Оршин суух зөвшөөрөл авах төлбөр;
- 6.9.5 Эрүүл мэндийн шинжилгээний бичиг (Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас шаарддаг шинжилгээнүүд)
- 6.9.6 Сургуулийн гэрээ;
- 6.9.7 Дижитал цээж зураг (сүүлийн 6 сарын дотор авхуулсан, 3x4 хэмжээтэй байх);
- 6.9.8 Гэр бүлийн гишүүнээ урьсан бол гэрлэлтийн баталгаа, хүүхдээ урьсан бол төрсний гэрчилгээ;
- 6.9.9 Хувийн зардлаар суралцаж байгаа бол санхүүгийн баталгаа.
- Дээрх болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн үед шаардах бусад материалыг (англиас бусад хэлээрх) монгол хэлээр орчуулсан байх шаардлагатай.
- 6.10 МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлийн жилийн тухайн улирлын эхний хоёр долоо хоногт багтан суралцахаар ирвэл элссэн тухай тушаал гарган, тухайн улирлын хичээлийг судлах эрх өгөх ба дурдсан хугацаанаас хойш ирвэл дараагийн улирлын эхнээс хичээл судлах эрх олгоно.

Долоо. Суралцах үйл ажиллагааг зохицуулах

- 7.1 МУИС-ийн суралцагч болсон гадаад иргэн нь Монгол Улсын харьяат суралцагчийн адил дүрэм, журмын дагуу суралцана.
- 7.2 Суралцагчийн оршин суух зөвшөөрлийн хугацааг суралцаж буй бүрэлдэхүүн/салбар сургууль, нэгжийн тодорхойлолт, сурлагын байдал,

- гэрээний биелэлт зэргийг үндэслэн жил бүр сунгах асуудлыг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж зохион байгуулна.
- 7.2.1 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь суралцагчийн бүртгэлийг хөтөлж, оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө сануулна.
- 7.2.2 Суралцагч нь оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид бичлэн хандаж, шаардлагатай материалыг бүрдүүлэн зөвшөөрлийн хугацааг сунгуулах үүрэгтэй.
- 7.2.3 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж танхимын сургалтад хамрагдаж буй суралцагчийн ирц болон дүнгийн мэдээллийг үндэслэн оршин суух зөвшөөрлийг жил бүр сунгуулна.
- 7.2.4 Танхимын сургалтын бүрэн багц цагийг судалж дууссан ахисан түвшний суралцагч нь Монгол Улсад судалгааны ажлаа үргэлжлүүлэн хийх тохиолдолд оршин суух зөвшөөрлийг удирдагч багшийн тодорхойлолтыг үндэслэн хоёроос дээшгүй удаа сунгуулж болно. Удирдагч багш үнэн зөв тодорхойлолт болон судалгааны ажлын төлөвлөгөөг гаргаж өгөх үүрэгтэй. Хэрэв нутаг буцсан тохиолдолд хамгаалах хугацааг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид урьдчилан мэдэгдэж, Монгол Улсад нэвтрэх виз авна.
- 7.2.5 Хуульд заасан хугацаанд сунгуулаагүй тохиолдолд холбогдох хариуцлага, гарах торгууль шийтгэлийг суралцагч өөрөө хариуцна.
- 7.3 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь Монгол Улсад буцаж ирэхгүйгээр нутаг буцах суралцагчийн тойрох хуудсыг үндэслэн Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж, оршин суух үнэмлэхийг хүчингүй болгоно.
- 7.4 Монголын бусад их сургуулиас МУИС-д болон МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцах хүсэлтэй суралцагчийн хүсэлтийг "МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам"-ын дагуу шийдвэрлэнэ.
- 7.5 Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт хамрагдаж буй гадаадын иргэнийг өөр сургуульд шилжүүлэн суралцуулахгүй бөгөөд шилжин суралцах хүсэлт гаргасан тохиолдолд МУИС-ийн урилгыг цуцалж, сургуулиас хасна.
- 7.6 Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь сургууль төгсөх, хасагдах, шилжих, чөлөө авах зэрэг шалтгаанаар сургалтаа зогсоосон суралцагчийн төлөв өөрчлөгдсөн мэдээллийг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид мэдэгдэнэ. Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь тухайн суралцагчийн Монгол Улсад оршин суух зохих ангиллын визийн зөвшөөрлийг цуцалснаар Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь долоо хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүртгэлд төлөвийг өөрчилнө.
- 7.7 Гадаадын иргэний МУИС-д элсэн суралцах хүсэлт шийдвэрлэгдсэнээс хойших Монгол Улсад ирэх, түр бүртгэлд хамруулах, оршин суухтай холбоотой асуудлууд, зөвлөн чиглүүлэх, дасан зохицох, гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, суралцах хугацааны дэмжлэг үйлчилгээ, нийгэм, соёлын хөтөлбөрт хамруулах асуудлыг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж хариуцна.

Найм. Сургалттай холбогдох төлбөр, хураамж



- 8.1 Гадаадын иргэний судлах хичээлийн багц цагийн төлбөр, онцутны байрны төлбөр, бусад төлбөр, хураамжийг жил бүр шинэчлэн тогтоож, МУИС-ийн Удирдах зөвлөл батална. Сургалтын төлбөрийг суралцагч улирал бүр төлнө.
- 8.2 Хоёр улсын Засгийн газар хоорондын болон хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах гадаадын иргэний сургалтын төлбөр болон амьдрах зардал, даатгал бусад зардлыг гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.3 МУИС-д суралцаж буй гадаадын иргэн суралцах явцдаа иргэний харьяаллаа сольж, Монгол Улсын харьяат иргэн болсон бол албан ёсоор Монгол Улсын иргэн болсон өдрөөс сургалтын мэдээллийн систем дэх иргэншлийн төлөвийг өөрчилнө. Сургалтын төлбөрийг дараагийн улирлаас эхлэн монгол суралцагчийн адилаар тооцно.
- 8.4 МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн нь амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал хийлгэсэн байна.
- 8.5 Цагаач нь Монгол Улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн шалгалтын оноогоор элсэн суралцсан бол сургалтын төлбөрийг Монгол Улсын харьяат суралцагчийн адилаар төлнө.

Ес. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр

- 9.1 Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах хүсэлтэй болон монгол хэл суралцах сонирхолтой, гадаадын иргэн монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцаж болно.
- 9.2 Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр анхан, дунд, гүнзгий түвшинтэй байна.
- 9.3 Монгол хэлний бэлтгэлийн сургалтын хөтөлбөрийг холбогдох мэргэжлийн тэнхим боловсруулан тэнхимийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж, хөтөлбөр хариуцсан нэгж баталгаажуулна.
- 9.4 Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрийн элсэлтийн үйл ажиллагааг бакалаврын зэргийн хөтөлбөртэй адил хугацаанд зохион байгуулна.
- 9.5 Элсэн суралцах хүсэлт гаргаж буй гадаадын иргэн дээр дурдсан хугацаанд багтаан дараах бичиг баримтуудыг бүрдүүлэн гадаад иргэний элсэлтийн бүртгэлийн цахим системээр, мөн шаардлагатай тохиолдолд өргөдлийн маягыг бөглөн холбогдох бичиг баримтын хамт foreignadmission@num.edu.mn цахим шуудангаар илгээж болно. Үүнд:
 - 9.5.1 Гадаад паспорт (хүчинтэй хугацаа 6 сараас дээш байх);
 - 9.5.2 Монгол Улсад суралцах хугацааны сургалтын төлбөр, амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан 1 жилийн сургалтын төлбөр, дотуур байрны төлбөртэй тэнцэх санхүүгийн баталгаа (тэтгэлэг, банкны тодорхойлолт болон түүнтэй дүйцэх баталгаа);
 - 9.5.3 Эрүүл мэндийн шинжилгээний бичиг (сүүлийн 3 сарын дотор эмнэлгээс олгосон байх);
 - 9.5.4 Дижитал цээж зураг (сүүлийн 6 сард авхуулсан, 3x4 хэмжээтэй байх).
- 9.6 Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцагч нь хичээлийн жилийн эцэст монгол хэлний түвшин тогтоох шалгалт өгөх бөгөөд дунд болон дундаас

дээш түвшинд амжилттай суралцаж төгссөн суралцагч боловсролын зэрэг олгох сургалтад элсэн суралцах эрхтэй болно.

- 9.7 Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт хоёр улирал суралцаж амжилттай төгссөн гадаадын иргэнд МУИС-ийн ректорын тушаалаар гэрчилгээ олгоно. Монгол хэлний мэдлэгийн түвшнийг илэрхийлэх үндсэн баримт бичиг буюу гэрчилгээнд тухайн гадаад иргэний суралцсан сүүлийн улирлын түвшнийг тусгана.



Арав. Оюутан солилцоо, интерншип хөтөлбөр

- 10.1 Оюутан солилцоо, интерншип хөтөлбөрийг МУИС-ийн гадаадын их, дээд сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжүүлнэ. Оюутан солилцооны гэрээг МУИС-ийн эсвэл бүрэлдэхүүн/салбар сургууль, сургалт, судалгааны нэгжийн түвшинд байгуулна.
- 10.2 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь оюутан солилцооны гэрээний бүртгэл, хэрэгжилт, тайлан мэдээг хариуцах бөгөөд тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх оюутан солилцоо, интерншип хөтөлбөрийн саналыг бүрэлдэхүүн/салбар сургууль, сургалт, судалгааны нэгжээс авч нэгтгэн, зар мэдээллийг бэлтгэж, хамтын ажиллагаатай сургуулиудад хүргүүлнэ.
- 10.3 Оюутан солилцооны хөтөлбөрийн элсэлтийн үйл ажиллагааг бакалаврын зэргийн болон монгол хэлний бэлтгэл хөтөлбөртэй адил хугацаанд зохион байгуулна.
- 10.4 Оюутан солилцооны хөтөлбөрт суралцах гадаадын иргэн нь 9.5-д заасан бичиг баримтуудыг бүрдүүлэн суралцах хүсэлтээ бүртгэлийн системд цахим болон шаардлагатай тохиолдолд өргөдлийн маягтыг бөглөн холбогдох бичиг баримтын хамт цахим шуудангаар илгээж болно.
- 10.5 Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан гадаадын иргэний холбогдох бичиг баримтыг хүсэлт гаргах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор хянаж, холбогдох бүрэлдэхүүн/салбар сургууль болон Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ. Гадаадын иргэний виз оршин суух зөвшөөрлийг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж зохион байгуулна.
- 10.6 Хамтын ажиллагааны гэрээний нөхцөлөөс шалтгаалан зэргийн бус сургалтын хэлбэрээр оюутан солилцоо, интерншип хөтөлбөрийг хэрэгжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд хөтөлбөрийн агуулга, сургалтын хэлбэр, хугацаа, үйл ажиллагааг харгалзах бүрэлдэхүүн/салбар сургууль шийдвэрлэнэ.
- 10.7 Хөтөлбөрт суралцагчийн дотуур байр, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг олгох асуудлыг хамтын ажиллагааны гэрээний дагуу шийдвэрлэнэ.
- 10.8 Хөтөлбөрт суралцаж төгссөн гадаадын суралцагчид дүнгийн тодорхойлолт, гэрчилгээ олгоно.
- 10.9 Хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуулийн оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах суралцагчийг гэрээнд заасан шалгуурт заасны дагуу Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж сонгон шалгаруулна. Уг хөтөлбөрт хамрагдах суралцагчтай Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж болон Сургалт,

хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж хоорондын гуравласан гэрээ байгуулна.

- 10.10 Гэрээнд хөтөлбөрт хамрагдах суралцагчийн суралцах хугацаа, сургалтын төлөвлөгөө, багц цаг, дүн дүйцүүлэлд, төлбөр, үүрэг, хариуцлагыг тодорхой заана. Хамтын ажиллагаатай сургуулиас Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж, бүрэлдэхүүн/салбар сургуульд ирүүлсэн тухайн суралцагчийн суралцсан хугацааны дүнгийн албан тодорхойлолтыг үндэслэн Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж багц цаг дүйцүүлэлтийг хийж, үргэлжлүүлэн суралцах нөхцөлөөр хангана.

Арван нэг. Зуны сургалт хөтөлбөр

- 11.1 Зуны сургалт хөтөлбөрийг бүрэлдэхүүн/салбар сургууль, сургалт, судалгааны нэгж хариуцаж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн мэдээлэл түгээх, сурталчлах, гадаадын иргэнийг бүртгэх, угтах, байрлуулах, танхимын сургалтад хамруулах зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтэд Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж дэмжлэг үзүүлж ажиллана.
- 11.2 Зуны сургалт нь батлагдсан хөтөлбөрөөр хэрэгжих бөгөөд сургалтын агуулга, хамрах хүрээ, чиглэл, хугацаа, үр дүн зэргийг тусгасан хөтөлбөрийг холбогдох бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.
- 11.3 Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй гадаадын иргэний мэдээллийг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд шаардлага хангасан гадаадын иргэнд визний зөвшөөрөл авах үйлчилгээг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж хариуцна.
- 11.4 Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь хөтөлбөрт оролцогч гадаадын иргэнийг Монгол Улсад ирэх үед сургалтын хөтөлбөрийн агуулга, хугацаа, оролцогчийн хариуцлага, чухал шаардлагатай үед тусламж авах боломж зэрэг мэдээллийг албан ёсоор танилцуулах бөгөөд хөтөлбөрт хамрагдах гадаадын иргэн нь амь нас, гэнэтийн ослын даатгалыг хийлгэсэн байна.
- 11.5 Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж оюутны дотуур байранд байрлуулах хүсэлтийг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 11.6 Хөтөлбөрт амжилттай суралцаж төгссөн гадаадын иргэнд гэрчилгээ олгоно.
- 11.7 Зуны сургалтын болон оюутны байранд байрлах төлбөрийг жил бүр МУИС-ийн Удирдах зөвлөлөөр хэлэлцэж батална.
- 11.8 Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь зуны сургалт дууссанаас хойш 14 хоногийн дотор хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг Оюутны үйлчилгээ хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 11.9 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь МУИС-ийн зуны сургалтын хөтөлбөрүүдийн мэдээлэл, хэрэгжилт, тайланг нэгтгэнэ.

Арван хоёр. Бусад

- 12.1 МУИС-д суралцаж буй гадаадын иргэн нь суралцах явцдаа шашин, терроризм, улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмыг мөрдөж, Монгол Улсын түүх соёл, ёс заншилд хүндэтгэлтэй хандана.
- 12.2 МУИС-д суралцаж буй гадаадын иргэн нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон, МУИС-ийн дүрмийн 6.7, МУИС-ийн Сургалтын журмын 4.11.3.2, МУИС-ийн Ёс зүйн дүрмийн 2.4.2 (186, 187) дүгээр заалтыг зөрчсөн тохиолдолд сургуулиас чөлөөлнө.
- 12.3 МУИС-д өмнө нь суралцах явцдаа Монгол Улсын хууль тогтоомж, сургуулийн дотоод дүрэм, журмыг зөрчиж сургуулиас хасагдсан гадаадын иргэн дахин суралцах эрхгүй.
- 12.4 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь МУИС-д суралцаж буй гадаадын иргэдийн талаарх судалгааг жил бүр гаргаж бүрэлдэхүүн/салбар сургууль, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 12.5 Оюутны үйлчилгээ хариуцсан нэгж нь оюутан солилцоо хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн талаарх судалгааг жил бүр гаргаж, Хамтын ажиллагаа хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 12.6 МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журмыг түгээмэл хэрэглэгддэг албан ёсны гадаад хэл (англи)-ээр орчуулан, контент хэлбэрээр бэлтгэн түгээнэ.